

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН

“ АГУЙТ”2-Р БАГИЙН ТАНИЛЦУУЛГА

Өлзийт сумын Агуйт2-р баг нь 1992 онд анх байгуулагдсан.

Агуйт 2-р багийн анхны Засаг даргаар:

Д.Наранмандах 1992-2000 онд

Ю.Энхбаяр 2000-2004 онд, ИНХ даргаар Д.Баяраа

Г.Пэрэнлэйдавга 2004-2012 онд ИНХ даргаар Ч.Сээсрэг

Б.Дашзэвэг- 2012-2016 онд , ИНХ даргаар Ц.Дэмбэрэлхүү

Ш.Гэндэн 2017 оноос өнөөг хүртэл, ИНХ даргаар 2017-2020 оны хооронд Д.Чулуундорж 2020-оноос өнөөг хүртэл ИНХ даргаар Ц.Алтангэрэл нар нь тус тус Багийн засаг дарга болон ИНХ даргын үүрэгт ажлыг гүйцэтгэж ирсэн байна.

Агуйт 2-р баг нь нийт 683 хүн амтай, 203 өрхтэй. 2021 оны жилийн эцсийн мал тооллогоноор нийт 33039 толгой мал тоологдсон.Үүнээс Тэмээ- 7, Адуу-2708, Үхэр-1533,Хонь- 19365 , Ямаа-9426 . Тус баг нь Дулаанхайрхан, Зүүн хайрхан, Их булаг хайрхан, Сангийн далай ,Эхийн цагаан суварга, Зэгстэйн гол, Галуут хад,Ноёнхайрхан, Могойн зам, Хүйсийн гол гэх мэт түүх дурсгалын болон байгалийн үзэсгэлэнт газрууд багтдаг .

Манай багаас Төр нийгмийн зүтгэлтэн ,Урлаг спортын алдартнууд, Улс ,Аймгийн аварга малчид олноор төрөн гарсан байдаг.

Хөдөрмөрийн баатар Хөгжмийн зохиолч Н.Жанцанноров, Гавъяат хуульч Д.Сугар, Гавъяат эдийн засагч Б.Сүхбаатар, Анагаах ухааны доктор О.Адъяа, Гавъяат дасгалжуулагч, Хилийн цэргийн хурандаа,Монгол Улсын Өсөх идэр начин Д.Дашжамц, Соёлын тэргүүний ажилтан уртын дуучин Дуламаа, И.Сумъяа, Улсын аварга малчин О.Доржсүрэн, Улсын аварга тууварчин Сумъяа, С.Мягмар, Аймгийн аварга тууварчин Д.Намсрайжав. Аймгийн аварга малчин Н.Гончиг, Д.Цэгмид, Б.Болоожав, Н.Пүрэвдаваа, Ц.Хадбаатар,Б.Насанбат,Д.Очирдорж, О.Нэргүй, Монгол Улсын начин С.Жаамаа, Аймгийн заан Д.Батмөнх, Аймгийн заан С.Уранмандах, Аймгийн начин, спортын дэд мастер Л.Ганбаатар, Аймгийн начин ,Спортын мастер Ш.Гэндэн, Аймгийн начин,Спортын мастер У.Болдбаатар.Монгол Улсын Алдарт уяач Д.Сугар,Аймгийн алдарт уяач Н.Гончиг гэх мэт олон олон алдартан , аваргууд төрөн гарсан байдаг.

Мөн тус баг нь 2007 онд Аймгийн Аварга багаар, 2010 онд тусгай 5-р байранд шалгарч байсан Аймгийн тэргүүний баг юм. Тус багийн малын эмчээр Алтан гадаст, Хөдөлмөрийн Гавъяаны Улаан Тугийн одонт зөвлөх эмч,Д.Чойжав ажиллаж байна.

Багийн дарга Ш.Гэндэн

2022.11.02